

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/014/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261815 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас: 261815 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди -Аудит ХХК Захирал: Д.Эхбаяр Утас: 99116948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (978-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНСҮХ ТАНАА

2025.02.04 № 07/644
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн өмнөх онуудад үүссэн нийт 68,265.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийн тооллогын комиссын тооцоо бодсон актаар 6,828.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдсан бөгөөд холбогдох этгээдээр төлүүлээгүй зөрчлүүд нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 заалтууд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дугаар тогтоолтой нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "Үнэлгээ ба хуваарилалт", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайланд онд үндсэн үйл ажиллагааны давсан орлого 669,250.7 мянган төгрөг,

Z:\Yawan_Bchgi\2025\0224_SNAO-14.Dox

1505070086

дээд шатны төсвийн захирагчийн "Эрүүл аюулгүй ажлын байр болзолт уралдаан"-ы орлого 32,800.0 мянган төгрөг, нийт 702,050.7 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 650,785.9 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авах зардал 4,266.6 мянган төгрөг, улсын мэдээний маягт хэвлэн, бэлтгэх зардалд 10,474.4 мянган төгрөг, "Эрүүл аюулгүй ажлын байр болзолт уралдаан"-ы шагнал урамшуулалд 16,000.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 16,800.0 мянган төгрөг нийт 698,326.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3,723.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 1,204,966.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,053,305.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөг 70.4 хувиар давж биелүүлж, давсан орлогоос 669,250.7 мянган төгрөгийг Сангийн сайдын 2024 оны 224 дугаар тушаалаар зарцуулах эрх олгосны дагуу ажилчдад урамшуулал олгох болон бусад зардалд зарцуулжээ.

Бусад асуудал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулж буй 106 сургалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээг хийсэн байна.

Тус байгууллагын Мэргэжлийн өвчин судлалын эмнэлэгт 2,593 өвчтөн мэргэжлээс шалтгаалсан өвчний хяналтад байдаг бөгөөд мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг салбараар нь авч үзвэл уул, уурхай олборлолт, барилгын салбар, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт хамгийн өндөр, нийт мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн 51 хувийг тоос, химийн хортой бодисоор үүсгэгддэг өвчин эзэлдэг байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *B. Ц. НАРАНЧИМЭГ* Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	639,862,849.29	202,720,441.76
33	АВЛАГА	331,887,890.84	120,207,859.37
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	14,301,722.90	13,549,337.71
335	Бусад авлага	317,586,167.94	105,265,339.00
3351	Байгууллагаас авах авлага	312,477,663.94	100,156,835.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,108,504.00	5,108,504.00
35	БАРАА МАТЕРИАЛ	307,974,958.45	82,512,582.39
351	Түүхий эд материал	162,773,243.74	32,178,215.99
35130	Эм боох материал	162,773,243.74	32,178,215.99
354	Хангамжийн материал	145,201,714.71	50,334,366.40
35410	Бичиг хэргийн материал	43,334,385.00	370,750.00
35420	Аж ахуйн материал	7,279,318.00	-
35430	Сэлбэг хэрэгсэл	14,889,800.00	-
35440	Түлш, шатах тослох материал	-	502,758.40
35470	Бусад хангамжийн материал	79,698,211.71	49,460,858.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,421,337,365.84	2,342,136,217.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,421,337,365.84	2,342,136,217.69
392	Биет хөрөнгө	2,353,766,212.65	2,284,762,897.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,279,846,891.00	2,279,846,891.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(495,899,571.62)	(550,553,339.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	176,900,000.00	176,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(176,900,000.00)	(176,900,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,305,251,244.10	1,393,259,961.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,081,882,712.98)	(1,138,002,623.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,846,552.08	154,697,922.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	(137,243,871.99)	(141,713,522.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	366,861,085.11	366,861,085.11
39215	Хуримтлагдсан элэгдэл	(38,476,803.05)	(38,476,803.05)
39217	Ном	1,463,400.00	1,463,400.00
393	Биет бус хөрөнгө	67,571,153.19	57,373,319.75
39301	Программ хангамж	142,042,500.00	142,042,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(122,354,666.81)	(132,552,500.25)
39303	Бусад биет бус хөрөнгө	47,883,320.00	47,883,320.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,061,200,215.13	2,544,856,659.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	256,513,563.78	5,911,528.55
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	256,513,563.78	5,911,528.55
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	98,128,157.38	887,898.55
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2,488,630.00
41361	Байгууллагад төлөх өглөг	36,405,876.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	656,515.00	-
414	Урьдчилж орсон орлого	121,323,015.40	2,535,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	121,323,015.40	2,535,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,804,686,651.35	2,538,945,130.90
51	Засгийн газрын хувь оролцоо	2,804,686,651.35	2,538,945,130.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	690,350,380.90	690,350,380.90
51101	Өмч:- төрийн	690,350,380.90	690,350,380.90
512	Хуримтлагдсан үр дүн	2,114,336,270.45	1,848,594,750.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,766,742,809.44	2,083,181,645.77
51220	Тайлант үеийн үр дүн	347,593,461.01	(234,586,895.77)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,061,200,215.13	2,544,856,659.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,883,181,844.86	4,352,745,538.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,801,970,784.86	2,120,518,838.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,801,970,784.86	2,120,518,838.40
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,223,507,453.00	2,120,518,838.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,223,507,453.00	2,120,518,838.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	420,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	578,043,331.86	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,081,211,060.00	2,232,226,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,710,512,500.00	2,199,426,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,710,512,500.00	2,199,426,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	370,698,560.00	32,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	370,698,560.00	32,800,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,535,588,383.85	4,587,332,434.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,535,588,383.85	4,587,332,434.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,217,841,228.55	4,355,693,807.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,177,822,876.29	3,031,026,116.60
210101	Үндсэн цалин	2,177,822,876.29	3,031,026,116.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	275,329,765.35	369,282,919.99
21020	Тэтгэврийн даатгал	275,329,765.35	369,282,919.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,234,005.10	19,412,727.63
210301	Гэрэл, цахилгаан	6,466,751.00	6,368,798.83
210302	Түлш, халаалт	9,094,550.00	9,718,050.00
210303	Цэвэр, бохир ус	7,672,704.10	3,325,878.80
2104	Хангамж, бараа материалын зардал	83,626,414.62	212,754,347.31
210401	Бичиг хэрэг	51,501,550.00	93,487,570.00
210402	Тээвэр, шатахуун		5,919,441.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,997,374.00	7,094,830.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,583,420.00	25,935,736.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	14,544,070.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	73,656,169.71
2105	Нормативт зардал	199,597,681.25	466,607,940.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	181,597,681.25	463,583,940.75
210502	Хоол, хүнс	18,000,000.00	3,024,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,870,000.00	3,509,250.00
210604	Урсгал засвар	3,870,000.00	3,509,250.00
2107	Томилолт, зочны зардал	28,365,500.00	47,891,200.00
210702	Дотоод албан томиллолт	28,365,500.00	47,891,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,417,503.00	35,714,870.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,071,920.00	29,581,870.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,384,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	367,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	289,983.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,100,000.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	260,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	321,577,482.94	169,494,435.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,150,900.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	173,786,340.00	1,433,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	144,640,242.94	168,061,235.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	317,747,155.30	231,638,626.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	221,827,800.00	80,807,162.03
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	192,924,800.00	64,807,162.03
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,903,000.00	16,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	81,156,834.30	150,831,464.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,156,834.30	150,831,464.71
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,762,521.00	-
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	14,762,521.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
2200	Дотоод эх үүсвэрээр		
220001	Барилга байгууламж		
222001	Тоног төхөөрөмж		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	347,593,461.00	(234,586,895.77)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	347,593,461.00	(234,586,895.77)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,472,570,828.00	4,285,531,843.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,395,058,328.00	4,285,531,843.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,395,058,328.00	1,384,054,443.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,393,981,813.00	1,384,054,443.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,391,353,253.00	1,384,054,443.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,628,560.00	-
120009	Бусад орлого	1,076,515.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,077,512,500.00	2,901,477,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,710,512,500.00	2,199,426,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,710,512,500.00	2,199,426,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	367,000,000.00	702,050,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	367,000,000.00	32,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	669,250,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,464,237,328.00	4,268,684,703.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,464,237,328.00	4,268,684,703.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,162,322,693.70	4,037,046,076.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,105,725,720.00	2,918,534,798.75
210101	Үндсэн цалин	1,055,660,512.24	1,406,159,808.68
210102	Нэмэгдэл	656,059,378.91	877,776,5744.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	152,330,314.73	205,855,378.10
210104	Урамшуулал	241,675,514.12	428,743,037.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,488,400.00	582,851,876.88
210201	Тэтгэврийн даатгал	175,782,800.00	458,834,325.90
210202	Тэтгэмжийн даатгал	18,426,300.00	32,935,047.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,741,200.00	18,535,994.93
210204	Ажилгүйдлийн даатгал	3,685,200.00	15,651,703.53
210205	Эрүүл мэндийн даатгал	36,852,900.00	56,894,804.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,234,005.10	19,412,727.63
210301	Гэрэл, цахилгаан	6,466,751.00	6,368,798.83
210302	Түлш, халаалт	9,094,550.00	9,718,050.00
210303	Цэвэр, бохир ус	7,672,704.10	3,325,878.80
2104	Хангамж, бараа материалын зардал	86,059,674.62	64,727,597.00
210401	Бичиг хэрэг	29,774,300.00	26,379,250.00
210402	Тээвэр, шатахуун	-	6,422,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,997,374.62	7,094,830.00
210404	Ном, хэвлэл	28,920,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал	-	6,660,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,368,000.00	18,170,717.00
2105	Нормативд зардал	291,928,335.00	327,647,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	273,928,335.00	322,610,500.00
210502	Хоол, хүнс	18,000,000.00	3,024,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,013,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,182,215.98	20,118,506.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	74,312,215.98	4,077,056.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	12,233,650.00
210604	Урсгал засвар	3,870,000.00	3,807,800.00
2107	Томилолт, зочны зардал	28,365,500.00	46,251,200.00
210702	Дотоод албан томилолт	28,365,500.00	46,251,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,818,043.00	56,068,670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,292,460.00	29,581,870.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,384,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	367,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	289,983.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,822,500.00	1,100,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,440,000.00	20,353,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,520,800.00	1,433,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	174,520,800.00	1,433,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	301,914,634.30	231,638,626.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	221,827,800.00	80,807,162.03
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	192,924,800.00	64,807,162.03
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,903,000.00	16,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	80,086,834.30	150,831,464.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,086,834.30	150,831,464.71
213304	Хөрөнгийн	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,333,500.00	16,847,140.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,333,500.00	16,847,140.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,333,500.00	16,847,140.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,333,500.00	16,847,140.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,333,500.00	16,847,140.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,333,500.00)	(16,847,140.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	690,350,380.90	-	1,496,455,174.84	2,186,805,555.74
	Тайлант үеийн үр дүн	-	-	270,287,634.60	270,287,634.60
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	690,350,380.90	-	1,766,742,809.44	1,766,742,809.44
7	Тайлант үеийн үр дүн	-	-	347,593,461.01	347,593,461.00
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	690,350,380.90	-	2,114,336,270.45	2,804,686,651.35
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(31,154,624.68)	(31,154,624.68)
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	690,350,380.90	-	2,083,181,645.77	2,773,532,026.67
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(234,586,895.77)	(234,586,895.77)
17	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	690,350,380.90	-	1,848,594,750.00	2,538,945,130.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,512,393,300.00	3,436,373,434.41	76,019,865.89	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,512,393,300.00	3,436,373,434.41	76,019,865.89	97.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,447,572,700.00	3,371,566,272.38	76,006,427.62	97.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,534,158,900.00	2,533,830,748.75	328151.25	99.99
210101	Үндсэн цалин	1,479,687,400.00	1,406,159,808.68	73,527,591.32	95.0
210102	Нэмэгдэл	741,357,700.00	674,967,841.52	66,389,858.48	91.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	122,052,100.00	205,855,378.10	(83,803,278.10)	168.7
210104	Урамшуулал	191,061,700.00	246,847,720.45	(55,786,020.45)	129.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	316,770,000.00	316,770,000.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	215,403,600.00	205,907,610.99	9,495,989.01	95.6
210202	Тэтгэмжийн даатгал	25,341,600.00	29,434,607.36	(4,093,007.36)	116.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,670,700.00	16,700,996.94	(4,030,296.94)	131.8
210204	Ажилгүйдлийн даатгал	12,670,800.00	13,833,873.04	(1,163,073.04)	109.2
210205	Эрүүл мэндийн даатгал	50,683,300.00	50,892,911.67	(209,611.67)	100.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,745,300.00	19,412,727.63	54,332,572.37	26.3
210301	Гэрэл, цахилгаан	26,370,900.00	6,368,798.83	20,002,101.17	24.2
210302	Түлш, халаалт	32,841,200.00	9,718,050.00	23,123,150.00	29.6
210303	Цэвэр, бохир ус	14,533,200.00	3,325,878.80	11,207,321.20	22.9
2104	Хангамж, бараа материалын зардал	43,771,800.00	43,660,980.00	110,820.00	99.75
210401	Бичиг хэрэг	9,604,800.00	9,579,250.00	25,550.00	99.7
210402	Тээвэр, шатахуун	7,161,300.00	6,442,200.00	739,100.00	89.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,430,800.00	7,094,830.00	(664,030.00)	110.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,904,100.00	13,904,100.00	-	100.0
2105	Нормативд зардал	344,318,200.00	327,647,500.00	16,670,700.00	95.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	322,610,500.00	322,610,500.00	-	100.0
210502	Хоол хүнс	19,450,000.00	3,024,000.00	16,426,000.00	15.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,257,700.00	2,013,000.00	244,700.00	89.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,971,400.00	36,965,646.00	5,754.00	99.98
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,924,200.00	20,924,196.00	4.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,329,400.00	12,233,650.00	5,750.00	100.0
210604	Урсгал засвар	3,807,800.00	3,807,800.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	46,269,200.00	46,251,200.00	18,000.00	99.96
210702	Дотоод албан томилолт	46,269,200.00	46,251,200.00	18,000.00	99.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,931,300.00	45,594,270.00	4,337,030.00	91.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,524,800.00	29,581,870.00	942,930.00	96.9

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	360,600.00	-	360,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	309,300.00	-	309,300.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	63,500.00	33,000.00	30,500.00	52.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,749,900.00	1,100,000.00	2,649,900.00	29.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,923,200.00	9,879,400.00	43,800.00	99.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,636,600.00	1,433,200.00	203,400.00	87.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,636,600.00	1,433,200.00	203,400.00	87.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,820,600.00	64,807,162.03	13,436.97	326.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,820,600.00	64,807,162.03	13,436.97	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,820,600.00	64,807,162.03	13,436.97	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,512,392,300.00	3,583,481,143.00	(71,087,843.00)	0.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,199,426,700.00	2,199,426,700.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,199,426,700.00	2,199,426,700.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,204,966,600.00	1,384,054,443.00	(146,287,843.00)	114.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,204,966,600.00	1,351,254,443.00	(146,287,843.00)	114.9
122001	Хандив тусламж/дотоод/	108,000,000.00	32,800,000.00	75,200,000.00	0.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	96	96	-	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	59	59	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	35	35	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	702,050,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	702,050,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	682,326,943.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	384,704,050.00
210102	Нэмэгдэл		202,808,733.04
210104	Урамшуулал		181,895,316.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	266,081,876.88
210201	Тэтгэврийн даатгал		252,926,714.91
210202	Тэтгэмжийн даатгал		3,500,440.49
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,834,997.99
210204	Ажилгүйдлийн даатгал		1,817,830.49
210205	Эрүүл мэндийн даатгал		6,001,893.00

2104	Хангамж, бараа материалын зардал	-	21,066,617.00
210401	Бичиг хэрэг		16,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,266,617.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	10,474,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		10,474,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	19,723,756.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		16,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,723,756.12
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		3,723,756.12
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	702,050,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	702,050,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		32,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		669,250,700.00

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 496.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 28.1 сая төгрөгийн алдааг залруулж, 467.9 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлж, 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1. Аудитаар нийт 28.1 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд ажилчдаас болон байгууллагаас авах 9,973.1 мянган төгрөгийн авлагыг үндсэн үйл ажиллагааны болон урьдчилж орсон орлого дансанд хааж бүртгэсэн.	1	9,973.1	-	-	1	9,973.1	1	9,973.1	-	-	-	-
Харилцагч байгууллагад тооцоо нийлсэн актаар төлөх 13,332.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулсныг санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй.	1	13,332.0	1	13,332.0	-	-	1	13,332.0	-	-	-	-
Харилцагч байгууллагаас 4,800.0 мянган төгрөгийн авлага үүсгэн бүртгэхдээ зардлыг бууруулж бүртгэсэн.	1	4,800.0	-	-	1	4,800.0	1	4,800.0	-	-	-	-
Дүн	3	28,105.1	1	13,332.0	2	14,773.1	3	28,105.1	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

3.2. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 89.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 89.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж, 3 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 заасан бүрэлдэхүүний дагуу гаргаагүй.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Тайлант онд элэгдлээрээ анхны өртөг нөхсөн 113,144.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн байна. Орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөхгүй, давсан орлогоос урамшуулал, бусад зардалд зарцуулж байгаа нь төсвийн хэмнэлтийн талаар хэрэгжүүлж байгаа бодлого, чиглэлтэй нийцэхгүй байна. Тухайлбал: Үндсэн үйл ажиллагааны орлогыг 1,204,966.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,053,305.2 мянган төгрөгийн орлого орсон нь төлөвлөгөөг	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

70.4 хувиар давж биелүүлж, давсан орлогоос 669,250.7 мянган төгрөгийг Сангийн сайдын 2024 оны 224 дугаар тушаалаар зарцуулах эрх олгосны дагуу ажилчдад урамшуулал олгох болон бусад зардалд зарцуулсан байна.												
Өмнөх онуудад үүссэн нийт 68,265.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	68,265.9	-	-	1	68,265.9	-	-	-	-	-	-
Тайлант оны үндсэн хөрөнгийн тооллогын комиссын тооцоо бодсон актаар 6,828.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдсан бөгөөд холбогдох этгээдээр төлүүлээгүй байна.	1	6,828.4	-	-	1	6,828.4	-	-	-	-	-	-
Үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 14,741.0 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс, улсын мэдээллийн маягт худалдан авах зэрэгт зарцуулсан бөгөөд орлогыг зарцуулах тухай байгууллагын даргын тушаалыг зарцуулалт хийсний дараа нөхөн гаргасан.	1	14,741.0	-	-	1	14,741.0	-	-	-	-	-	-
Дүн	6	89,835.3	-	-	3	89,835.3	3	-	-	-	-	-

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.3. Нийцлийн аудиттай холбоотой нийт 378.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 378.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 329,510.8 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээг хугацаа хоцроож, 48,542.0 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	378,052.8	1	378,052.8	-	-
Дүн	1	378,052.8	1	378,052.8	-	-